



ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ-Т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

МОНОПОЛЫН ЭСРЭГ ГАЗАР

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 32 25, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@ama.gov.mn,
Цахим хуудас: www.ama.gov.mn

2024.11.22 № 01/1960

танай _____-ны № _____-т

Тендер түдгэлзүүлэх тухай

Танай үйлдвэрээс зарласан “Засвар механикийн заводын механик цехийн өргөтгөлийн ажил” ЭҮТӨҮГ/202401011285 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Уудам булаг” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт заасны дагуу гомдлыг хянан шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг тендер шалгаруулалттай холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилт, тендер хүлээн авах, нээлт хийх үйл ажиллагааг түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Тус газарт тендерийн баримт бичиг, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл болон бусад холбогдох шаардлагатай баримт бичгийг албан бичгээр болон цахим шуудангаар (buyanjargal@ama.gov.mn) 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА



Б.БИЛГҮҮН

152400000898



ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ-Т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

МОНОПОЛЫН ЭСРЭГ ГАЗАР

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170

Утас: 26 32 25, Факс: (976-11) 32 00 41,

Цахим шуудан: contact@ama.gov.mn,

Цахим хуудас: www.ama.gov.mn

2024.12.02 № 03/2018
танай _____-ны № _____-Т

Тендерийн баримт бичиг
хянасан тухай

Танай үйлдвэрээс зарласан “Засвар механикийн заводын механик цехийн өргөтгөлийн ажил” ЭҮТӨҮГ/202401011285 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Уудам булаг” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 19.1-д “3. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “Шаардана” а) 2021, 2022, 2023 оны аль нэг жилд үйлдвэрийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байна. Энэхүү туршлагад тооцуулах 2021, 2022, 2023 оны гэрээний үнийн нийлбэр нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна, б) Ижил төстэй ажилд: 30 метр хүртэл алслалтай металл каркас үйлдвэрийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан туршлагыг тооцох ба энд зааснаас өөр ангилалд хамаарах ажлыг тооцохгүй” гэж тус тус заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална” гэж, 17 дугаар зүйлийн 17.2.1-д “Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт” гэж, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/259 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Жишээ: батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн [●] хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг ТШЗ 17.2-т заасан хугацаанд доод тал нь [●] удаа байх. Захиалагч ижил төстэй ажлыг тухайлан зааж болно.]” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д заасан шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ

152400000990

худалдан авах тухай хуулийн 11.1, 17.2.1 дэх хэсэгт заасны дагуу боловсруулсан байна.

Иймд тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг үүгээр мэдэгдэж байна.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Э.ЭРДЭНЭЦЭЦЭГ